



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/227

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5 дахь заалтууд, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 02/107 дугаар актыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймгийн "Орон сууцны алба" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй, аж ахуйн материал данс дахь эргэлтийн хөрөнгөд төрийн аудитын байгууллагаас тогтоосон актын төлбөрийг барагдуулж, улсын бүртгэлээс хасалт хийх ажилд шаардагдах хөрөнгийг зарцуулсугай.

2. Шаардагдах 2,882,320 (хоёр сая найман зуун наян хоёр мянга гурван зуун хорь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Л.Хаш-Эрдэнэ), Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч (Д.Ундрахбаяр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

